



# ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

**30** ЖИЛ  
МӨРӨӨДЛИЙГ ХӨТӨЛСӨН  
МАНДАХ ИХ СУРГУУЛЬ



📍 Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо,  
Амарсанаагийн гудамж 18/1, УБ-16040, Ш/Х:88  
☎ 7018-5950, 7018-5949  
✉ info@mandakh.edu.mn  
🌐 www.mandakh.edu.mn



# ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

## 1992 он

Бүдхүүгийн Сандагсүрэнгийн санаачилгаар МАНДАХ ИХ СУРГУУЛЬ үүсгэн байгуулагдав.



## 1996 он

- Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэв.
- Анхны төгсөлтөө хийлээ.



## 1998 он

- Нягтлан Бодох Бүртгэлийн улсын Олимпиадыг санаачлан зохион байгуулав.
- Нягтлан бодох бүртгэлийн улсын анхдугаар олимпиадад ТЭРГҮҮН байр эзлэв.
- Сургууль өөрийн хичээлийн байртай болов.

## 2006 он

- Нягтлан бодох бүртгэлийн бакалаврын хөтөлбөр магадлан итгэмжлэгдэв.
- Нийгмийн даатгалын ерөнхий газраас "Улсын тэргүүний шимтгэл төлөгч" хүндэт өргөмжлөл хүртээв.



## 2005 он

- Хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдэв.
- Нягтлан бодох бүртгэлийн VII олимпиадад 2 байр эзлэв.



## 2007 он

- Дархан – Уул аймагт салбар сургууль нээв.
- Бизнес хөгжлийн гарц холбооноос Оны шилдэг аж ахуйн нэгж цом өргөмжлөлөөр шагнав.



## 2010 он

- Монголын хувийн Их дээд сургуулиудын Холбооноос "Шилдэг их, дээд сургууль"-иар шалгаруулж Хүндэт өргөмжлөл олгов.
- Дархан-Уул аймаг дахь салбар сургууль Дархан-Уул аймгийн "Шилдэг менежменттэй сургууль" -аар шалгарав.



## 2018 он

- Үндэсний хэмжээнд 4 дэх удаагаа магадлан итгэмжлэгдэв.
- Мэдээлэл технологийн бүрэлдэхүүн сургуультай болж өргөжив.
- Орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн цогцолбор Шинэ хичээлийн байрыг ашиглалтанд оруулав.
- "2018 ОНЫ ОНЦЛОХ БАЙГУУЛЛАГА" /Дэлхийн бизнесийн нэгдсэн холбоо/.
- "2018 ОНЫ ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" МНСК
- Докторын хөтөлбөр нээв.
- Швейцарын Холбооны Улсын Эдийн засаг, технологийн сургуультай хамтарсан Хос диплом олгох хөтөлбөрөөр анхны төгсөлт хийв.

## 2017 он

- Мандах Их Сургууль нэртэй боллоо.
- Чанарын удирдлагын ISO9001:2015 стандартыг хувийн их дээд сургуулиудаас анх удаа нэвтрүүлээ.
- Европын Бизнес Ассамблейн бүс нутгийн шилдэг байгууллагаар шалгарлаа.
- "Мандах-2017" ОУЭШХ 3 дахь удаа зохион байгуулав.
- Статистикийн улсын олимпиадыг санаачлан зохион байгуулав.

## 2019 он

- НББ-ийн хөтөлбөр үндэсний хэмжээнд 4 дэх удаагаа магадлан итгэмжлэгдэв.
- БУ-ын Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэгдэв.
- НББ-ын улсын XXI олимпиадад тэргүүн байр эзэлж, үнэмлэхүй амжилт тогтоов.
- "Мандах-2019" ОУЭШХ 4 дэх удаа зохион байгуулав.



## 2020 он

- ISO21001:2018 Боловсролын менежментийн тогтолцоог Монголын боловсролын байгууллагаас анх түрүүн хэрэгжүүлж, гэрчилгээ гардан авлаа.
- Хичээлийн С байрыг ашиглалтад оруулав.
- Оюутны байрыг ашиглалтад оруулав.
- Мандах лицей ахлах сургууль байгуулав.



## 2021 он

- Мандах Их Сургуулийн бүрэлдэхүүний:
  - "Ахисан түвшний сургууль"
  - "Нягтлан бодох бүртгэлийн сургууль"
  - "Инженер эдийн засгийн сургууль" тус тус байгуулав.
- Мандах Лицей ахлах сургууль анхны элсэлтээ авлаа.
- "Татварын бүртгэл 2021" улсын олимпиадад Нягтлан бодогч, татварын улсын байцаагчийн ангилалд: Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн ахлах багш М.Энхсүрэн Тэргүүн байр, багш Б.Ганбагана Гутгаар байрт шалгарлаа.
- Мандах Их Сургууль "Ээлтэй байгууллага 2021"-ээр тодорлоо.
- МТС-ийн багш, оюутнууд хамтран хэлд орж байгаа бяцхан үрс үг сурахад зориулагдсан "Хүүхэд" апп бүтээсэн.





### 2000 он

- Дундговь аймагт салбар сургуулиа нээв.
- Нийслэлийн Хэрэглэгчдийн найдвартай түнш байгууллага болов.



### 2001 он

- Нягтлан бодох бүртгэлийн улсын дөрөвдүгээр олимпиадад тэргүүн байр эзлэв.
- Магистрын хөтөлбөр нээв.



### 2003 он

- “Тэргүүний татвар төлөгч байгууллага” гэрчилгээ хүртэв.
- “Хэрэглэгчийг Хаанд өргөмжилсөн хамт олон” өргөмжлөл хүртэв.
- Магистрын анхны төгсөлт болов.



### 2002 он

- Нягтлан Бодох Бүртгэлийн улсын тавдугаар олимпиадад тэргүүн байр эзлэв.
- 10 жилийн ойгоо тэмдэглэв.




### 2012 он

- НББ-ийн 15-р олимпиадад тус сургуулийн оюутнууд амжилттай оролцсон ТОП-10-ын эхний 5 байрт шалгарч багийн дүнгээр Алтан медаль хүртэн үнэмлэхүй амжилтыг тогтоов
- 20 жилийн ой тэмдэглэв.



### 2014 он

- АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийг магадлан итгэмжилдэг ACBSP байгууллагаар сургууль болон сургалтын хөтөлбөрүүдээ магадлан итгэмжлүүлсэн Монголын анхны хувийн их сургууль боллоо.



### 2016 он

- Менежментийн улсын олимпиадад Дархан салбар сургуулийн баг Тэргүүн байр эзлэв.
- “Татварын бүртгэл-2016” онлайн олимпиадад Тэргүүн байр эзлэв.
- Хаан банкны нэрэмжит олимпиадад багийн дүнгээр 2-р байрт шалгарав.
- Нягтлан бодох бүртгэлийн улсын XVIII олимпиадад Дархан салбар сургууль хоёрдугаар байр, төв сургууль гуравдугаар байрт шалгарав.

### 2015 он

- Хувийн их дээд сургуулиудын холбооноос “Чанарын баталгаажуулалттай сургууль” өргөмжлөл олгов.

## Таны сонголт Мандах Их Сургууль

- 01 Чанартай сургалт, чадварлаг боловсон хүчинтэй
- 02 Сургуулийн нэрэмжит болон бусад олон төрлийн “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-т хамрагдах боломжтой
- 03 Шилдэг сургалтын хөтөлбөртэй
- 04 Хотын төвд байрлалтай, суралцах таатай орчин бүрдсэн.
- 05 Хос дипломын болон хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг
- 06 Орчин үеийн тохилог оюутны байртай

- 07 Үндэсний хэмжээнд болон олон улсад магадлан итгэмжлэгдсэн
- 08 Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр
- 09 Хөндлөнгийн олон улсын байгууллагаар хөтөлбөрөө үнэлүүлдэг
- 10 Төлбөр төлөх уян хатан нөхцөлийг санал болгодог.
- 11 ISO 9001:2015 олон улсын чанарын болон ISO 21001:2018 боловсролын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн.
- 12 Тулгуур эрхтэний бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчинг бүрдүүлсэн.

### АЛСЫН ХАРАА

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сургалт-судалгааны их сургууль болох

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Үндэсний болон олон улсын стандарт, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн боловсролын чанартай үйлчилгээ үзүүлж, оюунлаг чадварлаг судлаач мэргэжилтэн бэлтгэнэ.

### ҮНЭТ ЗҮЙЛС

Чанартай сургалт  
Чадварлаг мэргэжилтэн  
Ёс зүй, хариуцлага  
Оюунлаг, хүнлэг, нэгдмэл байдал

### УРИА

Бид мэдлэгээр баялгийг бүтээнэ

## СУРГУУЛИЙН ТУХАЙ

**Мандах Их Сургууль** нь 1992 онд байгуулагдсан хувийн хэвшлийн анхны сургуулиудын нэг бөгөөд эдүгээ **30 жилийн ой** тохиож байна.

**30** ЖИЛ  
МӨРӨӨДЛИЙГ ХӨТӨЛСӨН  
МАНДАХ ИХ СУРГУУЛЬ



Анхны хичээлийн жил /1992 он/

### Тус сургуулийн нэршлийн өөрчлөлтийн байдал

Нягтлан бодох бүртгэлийн “Мандах” дээд сургууль

1992.05.08

“Мандах бүртгэл” дээд сургууль

1996.08.01

“Мандах бүртгэл” Их сургууль

2017.08.01

“Мандах” Их Сургууль

2018.02.26

- ✓ Байгууллага болон хөтөлбөрөө үндэсний болон **Олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн**. ISO9001:2015 олон улсын чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн.
- ✓ Дэлхийн Бизнесийн Нэгдсэн Холбоо болон Европын бизнесийн холбооны Шилдэг байгууллагаар өргөмжлөгдсөн.
- ✓ 2020 онд Дээд Боловсролын менежментийн тогтолцооны **ISO21001:2018 олон улсын стандартыг** Монгол улсын хэмжээнд нэвтрүүлсэн анхны боловсролын байгууллага болсон.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн улсын 22 удаагийн олимпиадаас 11 удаа алтан медаль хүртсэн.

## ТУС СУРГУУЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ

Сургалтын материаллаг баазаа бэхжүүлж, үйл ажиллагаа бүрэн жигдэрсэн.

1992 - 1998 он

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн.

2007 - 2012 он

Монголын их, дээд сургуулиуд болон мэргэжлийн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг сургуулийн тоонд орсон.

1999 - 2006 он

Их сургуулийн түвшинд хүрч, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн.

2013 - 2018 он

Олон улсын стандартуудыг нэвтрүүлж, чанарыг эрхэмлэсэн манлайлагч сургууль болсон.

2019 - 2022 он

Бид 30 жилийн өмнө 10 хүрэхгүй багш, 60 гаруй оюутантай, түрээсийн байранд хичээлийн шинэ жилээ нээж байсан бол өнөөдөр Ахисан түвшний сургууль Дархан салбар сургууль, Мэдээлэл технологийн сургууль, Нягтлан бодох бүртгэлийн сургууль, Инженер эдийн засгийн сургуультай, 100 гаруй эрдэмтэн багштай, 2200 гаруй оюутантайгаар сургалтын үйл ажиллагааг явуулж байна.







# МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тус сургууль нь өнөөдрийн байдлаар төрийн болон төрийн бус 60 орчим байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, судалгаа, арга зүйн чиглэлээр хэлэлцүүлэг хийж, харилцан туршлагаа хуваалцах, оюутны дадлага хийх, мэргэжлийн чиглэлийн сургалт болон уралдаан тэмцээн зохион байгуулах, оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

## Бид гадаадын их дээд сургууль, байгууллагуудтай:

- Харилцан мэдээлэл солилцох
- Эрдэм шинжилгээний бага хуралд оролцох, хамтран зохион байгуулах
- Эрдэмтэн багш нар харилцан зочин профессороор ажиллах
- Оюутан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Эрдэм шинжилгээний ажилд хамтран оролцох

- Хос диплом олгох болон хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Олон улсын хурал, семинар, сургалтад эрдэмтэн багш, оюутнуудыг оролцуулах
- Богино хугацааны танилцах аяллыг зохион байгуулж, харилцан туршлага судлах зэргээр хамтран ажиллаж байна.



АНУ-ын дээд боловсролын чанарын байгууллага (ACBSP)



АНУ дахь олон улсын хөндлөнгийн үнэлгээний Peregrine академи



АНУ-ын Пэрэгрин Академик Сервис



Ази, Номхон далайн орнуудын оюутан солилцооны консорциум сургуулиудын мобилити хөтөлбөр

## Бакалавр болон магистрын хос диплом олгох хөтөлбөр



Швейцар улсын Эдийн Засаг, Технологийн Их Сургууль

## Багш болон оюутан солилцооны хөтөлбөрүүд



Япон улсын Тохоку Их сургууль



БНСУ-ын Коокмин Их Сургууль



Тайланд улсын Махасарахам Их сургууль



АНУ-ын Виржиниагийн Олон Улсын Их Сургууль



Австралийн Southern Cross Их Сургууль



Кипр улсын Зүүн Газар Дундын Тэнгисийн Их Сургууль



БНСУ-ын Хандонг Их Сургууль



Казахстан улсын Кокшетаугийн Их Сургууль



БНСУ-ын Кёнги Их Сургууль



Москва хотын Мэдээлэл холбоо, техникийн их сургууль



Вьетнам улсын FPT Бизнес технологийн их сургууль



Индонези улсын Стеком Шинжлэх ухаан, компьютерын их сургууль



Тайвань Ву Фенг их сургууль



АНУ-ын Нью-Жерси хотын их сургууль



ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн Их Сургуулийн Калугагийн салбар сургууль





# ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ ХӨНГӨЛӨЛТ



## БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧДАД ОЛГОХ ТЭТГЭЛГИЙН ТӨРӨЛ

- Шинэ элсэгчдийг дэмжих тэтгэлэг
- Сурлагын амжилтаар олгох тэтгэлэг
- Захирлын нэрэмжит тэтгэлэг
- Манлайлагч оюутныг дэмжих тэтгэлэг

### Бусад тэтгэлгүүд

- Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг
- Хаан, Голомт, Хас зэрэг банкуудын нэрэмжит тэтгэлгүүд
- Моннис группийн нэрэмжит - "Ирээдүйн манлайлагч" тэтгэлэг болон Зориг сан, Мягмаржав сан, Монгол такс ХХК-ийн тэтгэлэг
- Бусад төрийн ба төрийн бус байгууллагуудын тэтгэлгүүдээс хүртэх боломж танд бий.



## ШИНЭ ЭЛСЭГЧДИЙГ ДЭМЖИХ ТЭТГЭЛЭГ



### ЭЕШ

Шинэ элсэгчдийн ЭЕШ-ийн оноог харгалзан эхний хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрөөс **20-50 хувийн тэтгэлэг** олгоно. Харгалзах оноог тухайн хичээлийн жилийн элсэлтийн журамд зааснаар мөрдөнө.



Мандах ИС-иас уламжлал болгон зохион байгуулдаг Математик, Англи хэл, Мэдээлэл зүйн олимпиад болон бусад зохион байгуулсан тэмцээн уралдаанд **эхний 3 байр** эзэлсэн тохиолдолд хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрөөс **10-30 хувийн тэтгэлэг**



Улсын болон аймаг нийслэлийн хэмжээний Математик, Нийгэм, Физик, Мэдээлэл зүйн олимпиадад сүүлийн **2 жилд 1-3 байр** эзэлсэн тохиолдолд тухайн жилийн элсэлтийн журамд заасан хэмжээгээр тэтгэлэг олгоно.



Улсын болон аймаг нийслэлийн хэмжээний урлаг, спортын тэмцээн уралдаанд сүүлийн **2 жилд 1-3 байр** эзэлсэн тохиолдолд тухайн жилийн элсэлтийн журамд заасан хэмжээгээр тэтгэлэг олгоно.



Мандах Лицей ахлах сургуулийн төгсөгч нь Мандах ИС-д элсэн суралцсан тохиолдолд эхний хичээлийн жилийн I улирлын сургалтын төлбөрөөс **20 хувийн тэтгэлэг** олгоно.



Шинэ элсэгч нь **2 буюу түүнээс дээш тэтгэлгийн шалгуур** хангасан тохиолдолд аль өндрөөр нь олгоно.







## ОЮУТАН ХӨГЖЛИЙН ЗЭЭЛ

Оюутны хөгжлийн зээлийн зорилго нь оюутан, суралцагчийн сурах бололцоог нэмэгдүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

### Нөхцөл

- Тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр анх удаа бакалавр, магистр, докторын шатлалд суралцаж байгаа Монгол Улсын иргэн байх
- Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан байх.

### Тавигдах шаардлага

- Шинээр элсэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 600 болон түүнээс дээш байх
- Өдрийн ангид суралцаж байгаа бакалаврын шатлалын оюутны голч дүн 2.8 болон түүнээс дээш байх
- Өдрийн ангид суралцаж байгаа магистрант, докторантын голч дүн 3.2 болон түүнээс дээш байх
- Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэгдсэн байх
- Цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан элсэлтийн ерөнхий шалгалтад 500 болон түүнээс дээш оноо авсан элсэгч байх.

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- ✓ Иргэний үнэмлэхийн хуулбар
- ✓ Зээл хүссэн, эргэн төлөхөө илэрхийлсэн өргөдөл
- ✓ Элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн эх хувь
- ✓ Сургуулийн голч дүнг тусгасан тодорхойлолт
- ✓ Төлбөрийн нэхэмжлэхийн эх хувь
- ✓ Тухайн улиралд судалж байгаа хичээлийн баталгаажуулсан жагсаалт
- ✓ Ирээдүйн зорилгоо тодорхойлох эссе /зээлд хамрагдсанаар нийгэмд үзүүлэх хувь нэмэр, тухайн мэргэжлээр суралцсанаар ямар үр дүнд хүрэх талаарх/



## СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ, ТЭТГЭЛЭГ



Боловсролын зээлийн сангийн Боловсролын хөгжлийн хэлтэс нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг олгох төрийн үйлчилгээ үзүүлдэг юм.

### Дараах суралцагчид сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжаар суралцана.

- ✓ Бүтэн өнчин суралцагч
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч
- ✓ Эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч
- ✓ Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч
- ✓ Нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт зэрэг суралцаж байгаа тохиолдолд нэг суралцагч
- ✓ Цаатан өрхийн суралцагч





# МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮД

/2022-2023 оны хичээлийн жил/

Хөтөлбөр, мэргэжлийн чиглэл	Элсэгчдийн боловсролын түвшин	Элсэлтийн шалгалт өгөх хичээл
<b>БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨР</b>		
Нягтлан бодох бүртгэл	Бүрэн дунд	Математик, Гадаад хэл, Нийгмийн тухай мэдлэг
Санхүүгийн менежмент	Бүрэн дунд	
Банкны менежмент	Бүрэн дунд	
Бизнесийн удирдлага	Бүрэн дунд	
Логистик менежмент	Бүрэн дунд	Математик, Гадаад хэл, Нийгмийн тухай мэдлэг, Монгол хэл
Маркетингийн менежмент	Бүрэн дунд	
Инженер эдийн засаг	Бүрэн дунд	Математик, Физик, Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл, Монгол хэл
Инженер механик	Бүрэн дунд	
Цахилгааны инженер	Бүрэн дунд	
Программ хангамж	Бүрэн дунд	Математик, Физик, Гадаад хэл, Нийгмийн тухай мэдлэг, Монгол хэл
Мэдээллийн систем	Бүрэн дунд	
Гадаад хэлний орчуулагч /англи хэл/	Бүрэн дунд	Гадаад хэл, Монгол хэл, Нийгмийн тухай мэдлэг
<b>БАКАЛАВРЫН ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨР</b>		
Нягтлан бодох бүртгэл	Бакалавр	Нийгэм, Эдийн засгийн ерөнхий мэдлэг, Гадаад хэл
<b>МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРҮҮД</b>		
Нягтлан бодох бүртгэл	Бакалавр	Эдийн засгийн мэдлэг, Гадаад хэл
Санхүү	Бакалавр	
Банк	Бакалавр	
Даатгал	Бакалавр	
Бизнесийн удирдлага	Бакалавр	
<b>ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРҮҮД</b>		
Нягтлан бодох бүртгэл	Магистр	Судалгааны болон мэргэжлийн үр чадвар, Англи хэл
Эдийн засаг, Менежмент	Магистр	
Санхүү, Банк	Магистр	



## ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Бидний нэр хүндийн баталгаа



ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД БАЙГУУЛЛАГА БОЛОН ХӨТӨЛБӨРӨӨ МАГАДЛАН ИТГЭМЖЛҮҮЛСЭН СУРГУУЛЬ



ОЛОН УЛСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ХӨТӨЛБӨРӨӨ МАГАДЛАН ИТГЭМЖЛҮҮЛСЭН СУРГУУЛЬ



ISO 9001:2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХАМТ ОЛОН



ДЭЛХИЙН БИЗНЕСИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА



ЕВРОПЫН БИЗНЕС АССЕМБЛЭЙН БУС НУТГИЙН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА




БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХАМТ ОЛОН





# ЭЛСЭЛТИЙН ЗУРАГЛАЛ





# ЭЛСЭГЧДЭД ЗОРИУЛСАН Мэдээллийн төйм

## XI сар



### СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сургуулийн дэлгэрэнгүй танилцуулга, мэргэжил тус бүрийн танилцуулгыг веб хуудсаар цахим хэлбэрээр болон сургууль, боловсролын экспо, яармагаас хэвлэл хэлбэрээр танилцуулна.



## III сар

### СУРГУУЛИЙН НЭРЭМЖИТ ОНЛАЙН ОЛИМПИАД

ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдын дунд англи хэл, математик, мэдээлэл зүйн онлайн олимпиадыг зохион байгуулна.

## IV сар



### ЦАХИМ БҮРТГЭЛ

[elselt.mandakh.mn](http://elselt.mandakh.mn) веб хуудсаар орж бүртгүүлнэ.



## V сар

### НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ

Сургуулийн үйл ажиллагаа болон хичээлийн байрны талаар шинээр элсэн суралцахыг хүсэгчдэд мэдээлэл өгнө.

## VI-VII сар



### ЭЛСЭГЧДИЙГ ШАЛГАРУУЛЖ СУРАЛЦАХ ЭРХИЙН БИЧИГ ОЛГОХ

Тус сургуульд тэнцсэн элсэгчдэд суралцах эрхийн бичиг олгоно. Хөнгөлөлттэй нөхцөл Математик, Физик, Англи хэл, Мэдээлэл зүйн чиглэлийн үлс хотын нэрэмжит олимпиадад эхний аравт шалгарсан бол онооны дараалал харгалзахгүй элсэнэ.



## VIII сар

### БАТАЛГАА- ЖУУЛАЛТ

Суралцах эрхийн бичигтэй элсэгчдийг баталгаажуулан бүртгэж захирлын тушаал гарган оюутнаар батална.

## VIII сар



### ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТ

Шинээр элсэн суралцагчдад сургуулийн үйл ажиллагаа болон багш, ажилтнуудын танилцуулга, сургалтын хөтөлбөр, мэргэжлийн онцлог, ирээдүйд ямар мэргэжилтэн болж төгсөх талаар сургалт хийнэ



## IX сар

### ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТ

Хичээл сонголт хийнэ. Хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааны үеэр хөнгөлөлт авсан оюутнуудад батламж гардуулна.



# НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУРГУУЛЬ



## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУРГУУЛИЙН ЗОРИЛГО

Өндөр чанартай боловсролын үйлчилгээ үзүүлж нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн хөрвөх чадвартай, манлайлагч, судлаач мэргэжилтэн бэлтгэнэ.

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУРГУУЛИЙН ЗОРИЛТУУД

- Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны чанар, хүртээмжийг дээшлүүлэн нягтлан бодох бүртгэлийн хөгжилд хувь нэмрээ оруулна.
- Гадаад, дотоодын байгууллагуудтай сургалт, судалгааны чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийг дээдэлж, хувь хүний авъяас чадвар, тасралтгүй хөгжлийг дэмждэг сургалт, судалгааны орчин байна.



## БҮРТГЭЛ ШИНЖИЛГЭЭНИЙ ТЭНХИМ

Тус тэнхим нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийг заадаг. Тэнхимийн багш нар Монгол Улсад СТОУС-ыг нэвтрүүлэх, мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, судалгааг өргөн хүрээнд явуулж байгаагаас гадна оюутныг хөгжүүлэх дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- АСС клуб
- Цогц мэдлэг дугуйлан
- НББ-ийн мэргэжлийн АСТ /3-р курс/
- НББ-ийн үндэс хичээлийн олимпиад /1-р курс/
- Санхүүгийн бүртгэл хичээлийн олимпиад /2-р курс/
- Өртгийн бүртгэл хичээлийн олимпиад /3-р курс/
- НББ-ийн олимпиад /3,4-р курс/
- Онлайн олимпиад
- Санхүүгийн удирдлага хичээлийн олимпиад Улсын олимпиадын 1-ийн даваа


### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН АМЖИЛТУУД



11  
УДАА



5  
УДАА



4  
УДАА

## ГАДААД ХЭЛНИЙ ТЭНХИМ

Тус тэнхим гадаад хэлний сургалтыг тасралтгүй хөгжүүлэн, суралцагчдад зорилтот хэлээр харилцах чадвар эзэмшүүлэх гол зорилготой бөгөөд ерөнхий англи хэл, мэргэжлийн англи хэл, ахисан түвшний англи хэл, япон хэл, солонгос хэлний хичээлүүдийг зааж, мэдлэг чадваруудыг мэргэжлийн болон хэрэглээний түвшинд хүргэхэд чиглүүлэн сургалтаа явуулдаг. Түүнчлэн оюутнуудад гадаад хэл суралцах арга барил болон хэлний мэдлэгээ дээшлүүлэх, хөгжүүлэхэд нь чиглэсэн дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- “Их, Дээд сургуулийн мэргэжлийн англи хэлний сургалтын хөгжил” сэдэвт улсын хэмжээний онол, арга зүйн семинар
- Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн англи хэлний улсын олимпиад
- Мэргэжлийн англи хэлний тэмцээн
- Англи хэлний үр чадварын тэмцээн
- Англи хэлний “Онлайн” олимпиад
- Англи хэлний өдөрлөг

Мөн Гадаад хэлний тэнхимийн Хүмүүнлэг, Боловсрол Судлалын багаас оюутан суралцагчдад эрдэм шинжилгээ, судалгааны арга барил эзэмших орчин, боломжийг өргөжүүлэх зорилгоор Оюутны эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулдаг.





## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР



### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Үндэсний болон олон улсын дээд боловсролын стандарт, ажил олгогчдын шалгуур шаардлагыг хангасан, нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн, хөрвөх чадвартай, өндөр ёс зүйтэй нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэхэд оршино. “Нягтлан бодох бүртгэл” хөтөлбөрөөр суралцагч нь суурь хичээлүүд дээрээ дараах чиглэлийн багц хичээлүүдээс гүнзгийрүүлэн судалснаар таны хөрвөх чадвар нэмэгдэж, карьер өсөлтөд ач холбогдолтой байх болно Үүнд:

- А. Аудит
- Б. Статистик
- В. Татвар
- Г. Банк
- Д. Англи хэл
- Е. Мэдээллийн систем
- Ё. Эрх зүй



### ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ ЧАДВАР, ХАНДЛАГА

- Нягтлан бодох бүртгэлийн бодлого, технологийг тухайн байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, корпорацийн болон жижиг дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэх
- Байгууллагын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны явц, үр дүнд шинжилгээ хийж, өнөөгийн болон хэтийн төлөв байдлыг тодорхойлон санал, зөвлөмж боловсруулах
- Үйлдвэрлэлийн зардал, өртгийн тооцоо, удирдлагын бүртгэлийн талаарх шаардлагатай судалгаа, дүгнэлт мэдээ, тайлан гаргах
- Санхүү, удирдлага, татварын тайланг шалгаж хүлээн авах, тайлангийн үзүүлэлтүүдийн хэлбэлзлийн шалтгааныг шинжилж, дүгнэлт өгөх
- Санхүү, банк, татварын болон бусад харилцагч байгууллага, хүмүүстэй тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах
- Нягтлан бодох бүртгэлийн ажилтны мэргэжлийн ёс зүй, зөөлөн үр чадвар



### ХӨТӨЛБӨРӨӨР ОЛГОХ МЭДЛЭГ

- Нягтлан бодох бүртгэл, түүний бодлого зохицуулалт, мэдээлэл боловсруулах технологи ажиллагаа
- Санхүүгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандарт, санхүүгийн тайлан бэлтгэх, гүйцэтгэлийг шинжлэх арга зүй
- Татвар, даатгал, нийгмийн даатгалын төлбөр тооцоо, тайлагналын тогтолцоо

### ХӨТӨЛБӨРИЙН ДАВУУ ТАЛ

ХОС ДИПЛОМ олгох хөтөлбөрт хамрагдаж хамтын ажиллагаатай гадаадын их сургуулиуд болон МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН дипломтой төгсөх боломжтой.



### АЖЛЫН БАЙР

- Ерөнхий нягтлан бодогч (санхүүч)
- Санхүүгийн ажилтан
- Ахлах болон тооцооны нягтлан бодогч
- Татварын байцаагч
- Аудиторын туслах
- Банкны ажилтан
- Судлаач багш
- Бүртгэл санхүүгийн бусад ажлын байранд

## ГАДААД ХЭЛНИЙ ОРЧУУЛАГЧИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР



### ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ ЧАДВАР, ХАНДЛАГА

- Эдийн засаг, санхүү, бизнесийн шинжлэх ухааны ойлголт, зарчмыг судалж орчуулга хийх
- Баримт бичгийг эх хэл болон англи хэл дээр боловсруулах
- Англи, монгол хэлний хооронд үгсийн сангийн ба хэлзүйн хувиргалт хийх чадвар
- Англи хэлээр эх зохиох, тухайн сэдвийн хүрээнд үг хэллэг, найруулга зүйг хангасан орчуулгын утга санааг бүрэн дүүрэн зөв буулгах
- Англи хэлээрх эх бичвэрийн утга санааг бүрэн ойлгож үндэсний сэтгэлгээний онцлогийг илэрхийлсэн орчуулга хийх
- Англи болон эх хэлний хэрэглээг утга зохиолын хэлний хэм хэмжээнд хөрвүүлэхэд оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэглэх
- Онолын мэдлэгээ амьдралд хэрэгжүүлэх чадвар



### ХӨТӨЛБӨРИЙН ДАВУУ ТАЛ

Эдийн засаг, санхүүгээр гүнзгийрэн мэргэшсэн англи, монгол хэл, эдийн засаг, бизнес, түүх, соёлын гүн бат мэдлэгтэй англи хэлний орчуулагч болон бэлтгэгдэнэ. Өнөөдөр зах зээлд нягтлан бодох бүртгэл, бизнес, эдийн засгийн мэргэжлийн англи хэлний мэдлэг, чадвартай орчуулагчийн эрэлт хэрэгцээ их байгаа нь энэ мэргэжлийг сонгон суралцах давуу тал болно.



### АЖЛЫН БАЙР

- Англи хэлний орчуулагч, багш
- Хөтөч, тайлбарлагч
- Менежер, гадаад харилцааны ажилтан
- Төслийн болон эрдэм шинжилгээний ажилтан
- Гадаадын компанийн төлөөлөгч
- Хэл шинжлэлийн мэргэжилтэн, судлаач

# ИНЖЕНЕР, ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛЬ



## ИНЖЕНЕР, ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛИЙН ЗОРИЛГО

Инженер технологи, эдийн засаг бизнесийн чиглэлээр үндэсний болон олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай судлаач, мэргэжилтэн бэлтгэнэ.

## ИНЖЕНЕР, ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛИЙН ЗОРИЛТУУД

- Үндэсний болон олон улсын боловсролын стандарт шаардлагад нийцсэн үр дүнд суурилсан танхим болон танхимын бус сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны чанарыг дээшлүүлж, инновацид суурилсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн академик соёлыг төлөвшүүлнэ.
- Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж, мэргэжлийн чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж, мэргэжлийн чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

## ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ТЭНХИМ

Тус тэнхим нь сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын түшиц тэнхим болохын хувьд дотоод гадаадын эрдэм шинжилгээний хурлуудад тогтмол оролцож, олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, сурах бичиг боловсруулан гаргаад байна. Мөн үндэсний хэмжээний томоохон эрдэм шинжилгээний хурлуудад тэнхимийн дэргэдэх "Судлаач оюутан" клубийн оюутнуудаа амжилттай удирдан, оролцуулдаг гадна дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Эдийн засаг, бизнесийн судалгааны багийн нэрэмжит Мандах Их Сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээний бага хурал
- Их, дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулдаг оюутны эрдэм шинжилгээний хурал
- Эдийн засгийн мини олимпиад
- Банкны мэргэжлийн мини олимпиад
- Маркетингийн мини олимпиад
- Санхүү менежментийн мини олимпиад
- Үйлдвэрлэл, хөгжлийн гарц эссэ бичлэгийн уралдаан
- Маркетингийн өдөрлөг



## МАРКЕТИНГИЙН МЕНЕЖМЕНТ БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР



### ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ ЧАДВАР, ХАНДЛАГА

- Маркетингийн удирдлагын шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдлын судалгаа хийх, маркетингийн төлөвлөгөөнд тусгах стратеги болон тактикийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, багаар ажиллах
- Үйлчилгээний маркетингийн онцлогийг ялган мэдэж, үйл ажиллагааны оновчтой шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдалд үндэслэн үйлчилгээний зөв стратегийг маркетингийн төлөвлөгөөнд тусгах
- Судалгааны үе шатын дагуу зөв мэдээлэл цуглуулж, өгөгдөл дээр үндэслэн анализ хийхдээ оновчтой судалгааны арга барилыг сонгох, аливаа асуудлын гол мөн чанарыг ойлгон, дүн шинжилгээ хийх
- Идэвхжүүлэлтийн арга хэрэгслүүдийг уялдаа холбоотойгоор, хоорондын зөрчилгүйгээр хослуулж ашиглах
- Гадаад зах зээл дэх мэдээллийг цуглуулж, нэгтгэн, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр төлөвлөгөө, стратеги боловсруулах, тайлагнах
- Хэрэглэгчийг таньж судлах, зан төлөв, мөн чанарыг тогтоох, амьдралын хэв маяг болон сэтгэл зүйн хүчин зүйлийг тодорхойлох, худалдан авах шийдвэр гаргалтад үзүүлэх нөлөө, үр дүнг тайлбарлах
- Барааны тэмдгийг бүртгүүлэх, хамгаалах, эзэмших талаар хууль эрх зүйн мэдлэгийг олгох, шинэ брэнд

бий болгох, брэндийн хоногшуулалтыг оновчтой явуулах, байгууллагын брэндийн цогц төлөвлөгөө боловсруулах

- Байгууллагын маркетингийн талаарх вэб танилцуулга, баннер сурталчилгаа бэлтгэх, хөгжүүлэх, үр дүнг хэмжих, онлайн судалгааны онцлог, зорилтот сегментэд хүрэх стратегийг интернэтээр дамжуулан төлөвлөж, хийх
- Байгууллагын зорилгыг дэмжсэн сурталчилгааг олон нийтэд хүргэх маркетингийн төлөвлөгөө боловсруулж, мэдээллийн хэрэгслийг оновчтой сонгон боломжит төсвийг тооцоолох, үр ашгийг хэмжих
- Байгууллагын эрх зүйн баримт бичгийг бүрдүүлж, боловсруулах, багаар ажиллах
- Мэргэжлийн програм хангамжийг ашиглах ахисан түвшний чадвар



## АЖЛЫН БАЙР

- Маркетингийн менежер, мэргэжилтэн
- Брэнд менежер, мэргэжилтэн
- Борлуулалтын менежер, мэргэжилтэн
- Зах зээлийн судлаач
- Зар сурталчилгааны менежер, мэргэжилтэн
- Олон нийтийн харилцааны менежер
- Борлуулалт хариуцсан менежер
- Төр, улсын байгууллагад олон нийтийн харилцааны мэргэжилтэн
- Судлаач багш



## БИЗНЕСИЙН УДИРДЛАГА БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР



### ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ ЧАДВАР, ХАНДЛАГА

- Бизнесийн удирдлагын шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдлын судалгаа хийх, маркетингийн төлөвлөгөөнд тусгах стратеги болон тактикийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, багаар ажиллах
- Мэргэжлийн онцлогийг ялган мэдэж, үйл ажиллагааны оновчтой шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдалд үндэслэн үйлчилгээний зөв стратегийг маркетингийн төлөвлөгөөнд тусгах
- Зах зээлийн нөхцөлийг үнэлж, тулгарч буй асуудлуудыг тодорхойлох болон шийдвэрлэх боломжит хувилбаруудыг боловсруулах, үнэлгээний хэмжүүрүүдийг тодорхойлох, оновчтой төлөвлөх, зохион байгуулах
- Байгууллагад сургалт зохион байгуулах, сургалтын үр дүнг үнэлэх, ажиллагсдын карьер төлөвлөлт хийх
- Хэрэглэгчийг таньж судлах, зан төлөвийг мөн чанарыг тогтоох, амьдралын хэв маяг болон сэтгэл зүйн хүчин зүйлийг тодорхойлох, худалдан авах шийдвэр гаргалтад үзүүлэх нөлөө, үр дүнг тайлбарлах
- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, санхүүгийн тайланг бэлтгэх, гүйцэтгэлийг хэмжих арга зүй тодорхойлох
- Мөнгө, санхүү, эдийн засгийн онол дээр тулгуурлан удирдлагын оновчтой шийдвэр гаргах

